УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ

Өөрийн байр, Энхтайваны өргөн чөлөө/37,
15 дугаар хороо, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13373
Утас: (976-11) 45 09 60
Цахим шуудан: ubmuseum@gmail.com
Цахим хуудас: www.ubmuseum.mn

2026.06.26 № 102

танай 2026.06.04 -ны № 01/361 -т

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД

Улаанбаатар хотын музейгээс "Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх" 5 үзмэр сонгон үзмэрийн холбогдох судалгааг хийж батлагдсан маягтын дагуу мэдээллийг бэлтгэн илгээж байна.

Үзмэрийн гэрэл зураг болон бусад холбогдох мэдээллийг tegshjargal@ncch.gov.mn хаягаар илгээлээ.

Хавсралт 6 хуудастай.

Улаанбаатар хотын музей УТҮГ
Захиргаа
Захирал
Пагмажав ДАВААСҮРЭН
2026.06.26 13:25

УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН

“ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ” ДУРСГАЛЫН ЖАГСААЛТ

2026 оны 06 дугаар сарын 25

Улаанбаатар хотын музейн арга зүйн зөвлөл

Д/д	Үзмэрийн нэр	Хувийн дугаар	Тоо шир-хэг	Хэмжээ	Журмын 2.1.6 *(УБМС-ийн дугаар)*	Журмын 2.1.5 *(Судлагдсан, сурталчлагдсан байдал)*	Саналын үндэслэл
1	Нийслэл хүрээ –уран зураг	UBM74.23	1	Урт-282см, Өргөн-148см	ХД0110177	- Пүрэв, О. *Монгол төрийн голомт*, Улаанбаатар: 2004, 9-11, 36-38, 66, 90-93, 104 - Саруулбуян, Ж. *Зоогой аймгийн алдарт зураач Жүгдэр болоод түүний бүтээсэн Нийслэл хүрээ зургийн тухай*, Нийслэл хүрээ 100 жил, эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл, Улаанбаатар: 2012, 107-125 - Очбаяр, Г. *Богдын ордны алдарт зураач Жүгдэрийн “Нийслэл хүрээ” зураг*, Нийслэл guide сэтгүүл, 2014, №31, тавдугаар сар, 50-53. - Доржготов, О. *Бурхач Жүгдэрийн “Нийслэл хүрээ” зургийн зохиомж дүрслэлийн онцлог*, ШУА, ФСЭЗХүрээлэн “Эрдмийн ертөнц” эрдэм	ХХ зууны эхэн үеийн Монгол Улсын хамгийн том хот Нийслэл хүрээг монгол уран зургийн тэгээр зурсан бүтээл бол Жүгдэрийн зурсан Нийслэл хүрээ хэмээх зураг юм. Зоогой аймгийн алдарт зураач Жүгдэрийн 1910-аад оны үед зурсан Нийслэл хүрээ зураг өдгөө Богд хааны ордон музейд эх хувиараа хадгалагдаж байгаа бөгөөд хожим буюу 1946 онд БНМАУ-ын Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, уран зураач Д.Манибадар уг зургийг томруулан хуулбарлаж зурахдаа тухайн үеийн хүрээний аж амьдралыг баяжуулан зурсан нь өдгөө Улаанбаатар хотын музейд хадгалагдаж байна. Энэхүү бүтээлд 1910-аад оны Нийслэл хүрээний бүтэц, зохион

						шинжилгээний бичиг, 2012, 144-151 - Нацагдорж, Н. Очбаяр, Г. *Улаанбаатар хотын барилгажилтын түүх, гэрэл зургийн цомог*, Улаанбаатар: 2014, 24, 34, 38-39, 51, 54-55. - Очбаяр, Г. Цацралт, С. *Чингэлтэй хайрхны өвөрт, гэрэл зургийн цомог*, Улаанбаатар: 2015, 11, 16-17, 18, 20-21, 32, 55, 78, 109. - *Зураг болгомооргүй түүх (тусгай дугаар),* Үндэстний тойм сэтгүүл, №6 (157) 2013.02.11, 1-51. - Цэндсүрэн, Ц. Даваацэрэн, Б. *Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II*, Улаанбаатар: 2014, 134 - Очбаяр, Г. О.Одсүрэн.О. Улаанбаатар хотын түүхэн товчоон, Улаанбаатар: Нэпко 2024 - 2020.11.15 – Гэрээсээ музейд: Улаанбаатар хотын музейн онцлох таван үзмэр, ikon.mn - 2022.10.30-2022.11.01 - Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолборт дэглэсэн	байгуулалт, төрх байдал, бүлэг давхаргын ялгаа, амьдралын хэв маягийг бодитоор харуулдаг бөгөөд өдгөө XX зууны эхэн үеийн Монгол Улсын нийслэл хотын төрх байдлыг бодитоор харуулсан урлаг, зурагзүйн бүтээл төдийгүй түүхийн эх сурвалж болж байгаа учраас тус дурсгалыг үнэт үзмэрт нэр дэвшүүлж байна.

						“Хүндэтгэлийн хурал”-ын үзэсгэлэнд тавигдсан. - 2023.04.20 – Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолборт дэглэсэн “Өөрчлөгдөж буй Улаанбаатар өнгөрсөн ба одоо” үзэсгэлэнд тавигдсан. - 2023.05.27 – Баянзүрх дүүргийн Соёлын төвд дэглэсэн “Өөрчлөгдөж буй Улаанбаатар” үзэсгэлэнд тавигдсан.	
2	Сувдан чимэгтэй зээгт наамал	UBM61.68	1	Өндөр - 91.5 см Өргөн - 71.5 см	ХД0108743	- Цэндсүрэн, Ц. Даваацэрэн, Б. *Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II*, Улаанбаатар: 2014, 132 - Лхагвасүрэн, Б. Лонжид, З. *Монгол Улсын хосгүй үнэт үзмэрийн дээжис*, Улаанбаатар: 2020, 359 - Очбаяр, Г. О.Одсүрэн.О. Улаанбаатар хотын түүхэн товчоон, Улаанбаатар: Нэпко 2024 2008.03.10- 2008.10.07 Соёлын Өвийн Үндэсний Төвд сэргээн засварлуулсан.	Торгон зураг буюу зээгт наамлын урлаг нь Хүннү нарын үеэс улбаатай бөгөөд бурхны шашин дэлгэрэхэд тусгай нэгэн төрөл урлал болон хөгжсөөр XIX зуунд оргил үедээ хүрчээ. Тус зээгт наамалд Өндөр гэгээн Занабазарын өөрийн мутраар урласан “Долоон нандин” шүтээний нэг болох Очирдара бурхныг дүрсэлжээ. Очирдара бурхан нь Богд Жэвзүндамба хутагтуудын гол шүтээн байсан бөгөөд одоог хүртэл Гандантэгчэнлин хийдийн Батцагаан дуганы гол шүтээн хэвээр байна. Энэхүү бүтээл нь XX зууны эхэн үеийн монгол урчуудын ур ухааныг харуулсан бүтээл бөгөөд байгалийн шүр сувдаар

							гоёсон маш нарийн ур хийцтэй, “Хүрээ урлал”-ын торгон зургийн шилдэг бүтээлийн нэг учраас тус дурсгалыг үнэт үзмэрт нэр дэвшүүлж байна.
3	Л.И.Брежнев – уран хатгамал	UBM82.2	1	Өндөр - 125.4 см Өргөн – 68 см	ХД0057192	Цэндсүрэн, Ц. Даваацэрэн, Б. *Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II*, Улаанбаатар: 2014, 137	1981 онд Зөвлөлтийн удирдагч Леонид Ильич Брежнев БНМАУ-ын “Хөдөлмөрийн баатар” цолоор шагнагдахад түүнд зориулан уг бүтээлийг БНМАУ-ын Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт, нэрт уран хатгамалч А.Цэрэнхүү 1982 онд тус торго, даавуу, зэс утсаар бүтээжээ. Уг хатгамалд ЗСБНХУ-ын Төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Леонид Ильич Брежневийг амьд мэт тод томруун, уран нарийн оёж, уран зураг шиг дүрслэлийн ялгарлыг нарийн гарган хийсэн нь энэхүү бүтээлийг Монголын орчин үеийн уран хатгамлын урлагийн шилдэг бүтээлийн нэг болгосон байна. Энэхүү бүтээл нь А.Цэрэнхүүгийн уран хатгамлын оргил бүтээлийн нэг юм.
4	12 жилтэй янтай, жижиг цоожтой	UBM61.33-2	2	1.Янтай: Урт - 8.9см, Өргөн - 5.6 см Зузаан - 2.9см	ХД0107566	- Цэндсүрэн, Ц. Даваацэрэн, Б. *Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II*, Улаанбаатар: 2014, 122	Улаанбаатар хотын музейн сан хөмрөгт хадгалагдаж буй уг янтай, цоож нь XX зууны эхэн үеийн Хүрээний уран дархчуудын урласан сор бүтээлийн нэг юм. Янтайн дээд хэсгийг арван хоёр

				Жин – 188 гр 2.Цоож: У 1.9 см, Өр 1.7 см, Зу 1.1 см, жин 12.7 гр 3.Түлхүүр: урт -2.9 см Өргөн-0.7 см Жин – 1.2 гр		- Туул, Н. Анхбаяр, Д. Нийслэл хүрээ-110 жил үзэсгэлэн, Улаанбаатар: 2023, 48 - 2022.01.31-02.25 - Монголын үндэсний музейд дэглэсэн "Нийслэл хүрээ 110 жил" үзэсгэлэнд тавигдсан. - 2023.05.27 – Баянзүрх дүүргийн Соёлын төвд дэглэсэн "Өөрчлөгдөж буй Улаанбаатар" үзэсгэлэнд тавигдсан.	жилийн амьтнаар хүрээлж, түүний дотор талд дөрвөн хүчтэн, эвтэй дөрвөн амьтныг сийлж шармалдан, савны хоёр хажуу талыг цэцгэн хээ угалзаар чимэглэн өнгө зохилдлого, хийц загварыг нарийн гаргаж өгчээ. Цоожны нүүрэн хэсэгт товойлгон гаргаж шармалдсан арслангийн дүрстэй. Янтай нь бичиг, номын хүмүүсийн хэрэглэдэг хүмүүсийн бэх хийх зориулалт бүхий сав юм. Янтайн цоож нь монголын музейнүүдэд хадгалагдаж буй хамгийн жижиг цоож юм.
5	Түүхт Улаанбаатар – зааны соёон сийлбэр	UBM74.2	1	Урт: 161см, Өргөн: 12.6см Хэт: урт 42 см Өргөн 24 см	ХД0078332	- Бат-Очир, Р. *Урчуудын тухай тэмдэглэл*, Улаанбаатар: 1984 - Даваадаш, Н. *Өврийн хангайн зураач, урчуудын товчит*, Улаанбаатар: 2014, 192-193 - Цэндсүрэн, Ц. Даваацэрэн, Б. *Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис II*, Улаанбаатар: 2014, 137 - МҮОНРТВ *"Бөхийж үзээгүй далбаа"* баримтат нэвтрүүлэг - Соёлын Өвийн Үндэсний төвд 2008 онд сэргээн засварлуулсан. - Уран сайхны фондын хорооны тэргүүлэгчдийн 1974 оны 11	Тус дурсгалыг БНМАУ-ын нийслэл Улаанбаатар хотын 50 жилийн ойд зориулж БНМАУ-ын Урлагийн гавьяат зүтгэлтэн, чимэглэлийн урлагийн нэрт зүтгэлтэн, том хэмжээний ясан сийлбэрийн урлагийг Монгол Улсад тэргүүлэн хөгжүүлэгч С.Сэнгээ 1974 онд БНМАУ-ыг тунхагласны болон Улаанбаатар хотын 50 жилийн ойд зориулан зааны соёон дээр сийлж бүтээжээ. Тус бүтээлд тухайн цаг үеийн Улаанбаатар хотын барилга, архитектур, хөшөө баримал, түүх, соёлын дурсгалыг дүрсэлж, түүгээр дамжуулж хотын хөгжил

						дүгээр сарын 29-ны өдрийн 8/4 дугаар хурлын тогтоолын хавсралт №1-д 1-р байранд С.Сэнгээгийн “Түүхт Улаанбаатар” сийлбэр нь бусад 16 бүтээлийн хамт шалгарч 5000 төгрөгөөр үнэлэгдсэн байна. - 1999.10.26 – Нийслэлийн 360 жилийн ойд зориулсан музейнүүдийн шилмэл үзмэрийн үзэсгэлэнд тавигдсан. - 2004 – Улаанбаатар хотын 365 жилийн зориулсан үзэсгэлэнд тавигдсан. - 2009.10.19-2009.11.05 – Монголын үндэсний музейд дэглэсэн Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 370 жилийн ойн үзэсгэлэнд тавигдсан.	дэвшлийг харуулахыг зорьсон ба уг бүтээл нь зааны соёон дээр Улаанбаатар хотын барилга, архитектурыг цогцоор сийлсэн цор ганц бүтээл юм. Мөн монгол соёлын уламжлалаас, улс хувьсгалын түүхэн ялалт, их бүтээн байгуулалт, эх орны хөгжил цэцэглэлтийн маш баялаг үйл явдлыг уран нарийн дүрслэл, чимхлүүр нягт ажиллагаагаар дүрслэн үлдээсэн юм. Энэхүү бүтээлээс 1924 оноос 1974 он хүртэлх Их хотын бүтээн байгуулалтын түүхийг харж болно. Бүтээлийн уран нарийн хийц, загвар зохиомж, ашигласан материал зэргийг үндэслэн үнэт үзмэрийн саналд дэвшүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ

УНБМС-ийн дугаар: ХД0110174

Өмчлөгч: Монгол улс	
Эзэмшигч: Улаанбаатар хотын музей	**РД:** 9097104

Музейн зэрэглэл:	Орон нутгийн

Дурсгалт зүйлийн оршин байгаа хаяг:

Дурсгалт зүйлийн нэр: Нийслэл хүрээ	**Хувийн дугаар:** UBM74.23
Олон улс, орон нутаг, шинжлэх ухааны нэр: Зураг урлал	

Төрөл зүйл: 5. УРЛАГ, УРАН САЙХАН -> 5.1 Дүрслэх урлагийн бүтээл -> 5.1.1 Уран зураг

Холбогдох он цаг: XX зууны дунд үе

Соёлын өвийн зэрэглэл:	
Хосгүй үнэт	**Шийдвэр:**
Үнэт	**Шийдвэр:**

Эх бүтээл

Ховор, түгээмэл байдал:
Ашиглалтын байдал: Үзүүллэгт
Үнэлгээ: 11220000.00

Бүтээлчийн нэр:	Манибадар
Дэг сургууль хийц:	
Материал, арга ажиллагаа: Даавуу, гуашь, Даавууг залгаж, гуашиар монгол зургийн аргаар зурсан.	

Баримтжуулалтын гэрэл зураг:	**photo**	**photo**	**photo**

Хэмжээ	Өндөр	Өргөн (урт)	Зузаан	Голч	Жин
Ерөнхий	0.00	148.00, 282.00	0.00	0.00	0.00
Бусад хэмжээс: Жаазны өргөн 11 см					

Иж бүрдэл: 1	Тоо ширхэг
	1
Гарал үүсэл:	

Тодорхойлолт:
Дүрслэн бичих: 1910-аад оны Нийслэл хүрээний бүтэц, зохион байгуулалтыг Монгол зургийн аргаар дүрслэн зурсан. Зургийн төвд Зүүн хүрээ, Богдын шар ордон, түүний урд талын гэр хороолол, цэнхэр дээвэртэй байшингуудтай Баруун дамнуурчин, зүүн талд Баруун хүрээ, баруун доод буланд цэнхэр өнгийн дээвэртэй байшингуудтай Маймаа хот, зургийн доод талаар Туул голын хөвөөн дэх Богдын орднууд, Манзуширын хийд, Богд хан уулын хэсгийг дүрслэн оруулсан. Зургийн баруун доод буланд зураач гарын үсгээ монгол бичгээр бичсэн.
Тэмдэг бичээс:
Ялгагдах онцлог:
Зориулалт:

Иж бүрдлийн бүрэлдэхүүн хэсгийн мэдээлэл:

Хувийн дугаар	Тодорхойлолт	Хэмжээ

Хадгалалтын байдал:
Бүрэн бүтэн байдал: Бүрэн бүтэн
Чанар байдал: sain
Гэмтэл: 2 газар урагдсаныг нөхсөн. 1 ширхэг жижиг цоорсон. Доод хэсэгтээ зурагдсан.

Хамгаалалтад авсан шийдвэр:

Товч түүх:
Холбогдох газар, орон: 1910-аад оны Нийслэл хүрээний бүтэц, зохион байгуулалтыг Монгол зургийн аргаар дүрслэн зурсан. Зургийн төвд Зүүн хүрээ, Богдын шар ордон, түүний урд талын гэр хороолол, цэнхэр дээвэртэй байшингуудтай Баруун дамнуурчин, зүүн талд Баруун хүрээ, баруун доод буланд цэнхэр өнгийн дээвэртэй байшингуудтай Маймаа хот, зургийн доод талаар Туул голын хөвөөн дэх Богдын орднууд, Манзуширын хийд, Богд хан уулын хэсгийг дүрслэн оруулсан. Зургийн баруун доод буланд зураач гарын үсгээ монгол бичгээр бичсэн.
Хэрэглэж байсан хүн:
Цуглуулагчийн нэр: Улаанбаатар хотын музей
Бүтээлчийн түүх:

Бүртгэлийн түүх:
Хуучин хувийн дугаар: Y.136.162 УБТШБМ 99-Г-399-1
Ерөнхий бүртгэлийн дэс дугаар: 631
Төрөлжсөн бүртгэлийн дэс дугаар: ЗУ-114

Сэргээн засварлагдсан байдал:	СЗБ №

Хуулбар хийгдсэн байдал:

Үзэсгэлэнд оролцсон байдал:

Үзэсгэлэнгийн төрөл	Улс	Эхэлсэн огноо	Дууссан огноо	Үзэсгэлэнгийн нэр	Даатгалын үнэ

Судлагдсан байдал:

631. Нийслэл хүрээ Зүүн хэсэг - 1946 он Манибадар - Маймаа хот - Буяныг залбирагч сүм - Консул сайдын яам - Маахуур толгой - Зүүн дамнуурчин Төв хэсэг - Шашныг тэтгэгч Богд хаан хайрхан уул - Зайсан толгой - Хайстай лавиран - Ерөнхий яам - Дунд гол - Сэлбэ - Занхан сүм - Ёнзон хамба багш таны - Зүүн өмнө хороо - Зүүн харчууд - Нийслэл хүрээ - Буян ерөөлт сүм - Шашныг бадруулагч хийд - Чингэлтэй - Шадублин - Норовлин - Пандлин сүм - Билгийг хөгжүүлэн бадруулагч сүм - Шадар цэрэг - Баруун өмнө хороо Баруун хэсэг - Тасганы овоо - Орд - Гандантэгчэнлин - Ширээт - Гүнгаадэжидлэн сүм Хөрвүүлсэн эрдэм шинжилгээний ажилтан О.Одсүрэн

Хавсралт материалын тэмдэглэл:

Бүртгэсэн:

/_____/_____/

/ Овог, нэр/ */Албан газар, албан тушаал/*

/20.... оны ..... сарын ..... -ны өдөр/

Байгууллага, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын нэгдсэн (доогуур зур) бүртгэл-мэдээллийн санд хадгалагдаж байгаа:

Д/д	Нэр төрөл	Тоо ширхэг	Хадгаламжийн дугаар
1	Гэрэл зураг		
2	Негатив хальс		
3	Дуу, дүрс бичлэгийн хуурцаг		
4	CD/DVD/BD		
5	Архив, ном, хэвлэлийн баримт		
6	Бусад		

Бүрдүүлэлт хийсэн:

/_____/_____/

/ Овог, нэр/ */Албан газар, албан тушаал/*

/20.... оны ..... сарын ..... -ны өдөр/

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ

УНБМС-ийн дугаар: ХД0107566

Өмчлөгч: Монгол улс	
Эзэмшигч: Улаанбаатар хотын музей	**РД:** 9097104

Музейн зэрэглэл:	Орон нутгийн

Дурсгалт зүйлийн оршин байгаа хаяг:

Дурсгалт зүйлийн нэр: 12 жилтэй янтай, жижиг цоожтой	**Хувийн дугаар:** UBM61.33-2
Олон улс, орон нутаг, шинжлэх ухааны нэр:	

Төрөл зүйл: 2. ТҮҮХИЙН ЦУГЛУУЛГА -> 2.1 Түүхэн бие хүний холбогдолтой эд өлгийн зүйл -> 2.1.2 Эдэлж, хэрэглэж байсан эд зүйл

Холбогдох он цаг: XX зуун

Со

см, жин 12,7 гр Түлхүүр: Урт 2,9 см

өргөн 0,7 см жин 1,2 гр

явагдсан, сууринаасаа салж хөдөлсөн байсан. Сэргээн засварлалтаар хийгдсэн засварууд: Чийгтэй усан цэвэрлэгээ хийж, хагарал ан цав руу цавуу урсгаж наасан, нүүрэн талын хагаралд денмарк цавуу ашигласан, гадаргуу дээр акрилик будгаар өнгө тавьж өгсөн, суурийн улаан дэвсгэрийг шинээр сольсон, суурийн хүрээ модны хагарлыг нааж лакаар өнгөлгөө хийсэн, суурь хэтний сийлбэрийг өнгөлж лакадсан байна. Хадгалах орчин нөхцөл 20-230С, 45-50%ийн харьцангуй чийгшилтэй орчинд хадгалах зөвлөмж өгсөн. Мөн музейн сан хөмрөгт дараах 2 сийлбэр хадгалагдаж байна. Үүнд: 1. 1976 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Хотын гүйцэтгэх захиргаанаас УГЗ С.Сэнгээгийн бүтээсэн "Цэрэг сийлбэр" 400 төгрөгөөр худалдан авсан. (Зураг №3) 2. 1977 оны 3 дугаар сарын 21-ны өдөр УГЗ С.Сэнгээгийн бүтээсэн "Зааны ясан сийлбэртэй хөөрөг"-ийг 2500 төгрөгөөр хувь хүнээс худалдан авсан. (Зураг №4) Ашигласан материалын жагсаалт: 1. МҮОНРТВ "Бөхийж үзээгүй далбаа" баримтат нэвтрүүлэг 2. Р.Бат-Очир "Урчуудын тухай тэмдэглэл" (1984 он) 3. Ц.Ядамжав "Монгол ардын гар урлал" 2004 он 4. П.Мягмарсүрэн, П.Ганболд "Дүрслэх урлагийн нэр томъёоны тайлбар толь" 1985 он 5. Д.Гэвшээхүү "Монгол ардын гар урлагийн уламжлалт арга" 1970 он Эрхлэн боловсруулсан арга зүйч Б.Өлзийбаяр

Хавсралт материалын тэмдэглэл:

Бүртгэсэн:

/_____/_____/

/ Овог, нэр/ */Албан газар, албан тушаал/*

/20.... оны ..... сарын ..... -ны өдөр/

Байгууллага, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын нэгдсэн (доогуур зур) бүртгэл-мэдээллийн санд хадгалагдаж байгаа:

Д/д	Нэр төрөл	Тоо ширхэг	Хадгаламжийн дугаар
1	Гэрэл зураг		
2	Негатив хальс		
3	Дуу, дүрс бичлэгийн хуурцаг		
4	CD/DVD/BD		
5	Архив, ном, хэвлэлийн баримт		
6	Бусад		

Бүрдүүлэлт хийсэн:

/_____/_____/

/ Овог, нэр/ */Албан газар, албан тушаал/*

/20.... оны ..... сарын ..... -ны өдөр/

Иж бүрдэл: 2	**Тоо ширхэг**
	2
Гарал үүсэл:	

Тодорхойлолт:
Дүрслэн бичих: 1/Янтайн хайрцаг нь нугастай, голд нь эвтэй 4 амьтан дүрсэлж шармалдсан, тойруулан цэцгэн хээ, 4 хүчтэнийг дүрсэлсэн, гадна хүрээнд 12 жил дүрсэлсэн. Эргэн тойрон хээ угалзаар чимсэн. 2/Жижиг цоож нь түлхүүр, өргөс, их биеэс бүрдэнэ. Их бие дээр амаа ангайсан арсланг товойлгон шармалдсан.
Тэмдэг бичээс:
Ялгагдах онцлог:
Зориулалт:

Иж бүрдлийн бүрэлдэхүүн хэсгийн мэдээлэл:

Хувийн дугаар	Тодорхойлолт	Хэмжээ

Хадгал

тан дүрсэлж шармалдсан, тойруулан цэцгэн хээ, 4 хүчтэнийг дүрсэлсэн, гадна хүрээнд 12 жил дүрсэлсэн. Эргэн тойрон хээ угалзаар чимсэн. 2/Жижиг цоож нь түлхүүр, өргөс, их биеэс бүрдэнэ. Их бие дээр амаа ангайсан арсланг товойлгон шармалдсан. Хэрэглэж байсан хүн: Цуглуулагчийн нэр: Улаанбаатар хотын музей Бүтээлчийн түүх:
Бүртгэлийн түүх: Хуучин хувийн дугаар: УБТШБМ 99-У-616-1 Ерөнхий бүртгэлийн дэс дугаар: 114 Төрөлжсөн бүртгэлийн дэс дугаар: ТХХ-4

Сэргээн засварлагдсан байдал:	**СЗБ №**

Хуулбар хийгдсэн байдал:

Үзэсгэл

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ

УНБМС-ийн дугаар: ХД0108743

Өмчлөгч: Монгол улс	
Эзэмшигч: Улаанбаатар хотын музей	**РД:** 9097104

Музейн зэрэглэл:	Орон нутгийн

Дурсгалт зүйлийн оршин байгаа хаяг:

Дурсгалт зүйлийн нэр: Сувдан чимэгтэй зээгт наамал бурхан	**Хувийн дугаар:** UBM61.68
Олон улс, орон нутаг, шинжлэх ухааны нэр:	

Төрөл зүйл: 5. УРЛАГ, УРАН САЙХАН -> 5.4 Чимэглэлийн урлаг -> 5.4.1 Зээгт наамал

Холбогдох он цаг: XIX зууны сүүлч XX зууны эхэн үе

Соёлын өвийн зэрэглэл:	
Хосгүй үнэт	**Шийдвэр:**
Үнэт	**Шийдвэр:**

Эх бүтээл

Ховор, түгээмэл байдал:
Ашиглалтын байдал: Үзүүллэгт
Үнэлгээ: 3300000.00

Бүтээлчийн нэр:	
Дэг сургууль хийц:	
Материал, арга ажиллагаа: Шүр, сувд, торго, даавуу, утас,	

Баримтжуулалтын гэрэл зураг:	**photo**	**photo**	**photo**

Хэмжээ	Өндөр	Өргөн (урт)	Зузаан	Голч	Жин
Ерөнхий	91.50	71.50, 0.00	0.00	0.00	0.00
Бусад хэмжээс: Жаазны Өн 106.5 см, Өр 86.6 см					

Иж бүрдэл: 1	Тоо ширхэг
	1
Гарал үүсэл:	

Тодорхойлолт:
Дүрслэн бичих: Бүтэн очир завилгаа суудалтай, 2 мутартаа очир барьсан, зөөлөн амарлингуй дүртэй. Гоёл чимгийг сувд шүрээр хэлхэж чимэглэсэн, дээд хэсэгт нь нар, сар, цэцэг, навч, үүл, тэнгэр дүрсэлж, доор нь арга билгийг билэгдсэн догшин дүртэй бурхан дүрсэлсэн.
Тэмдэг бичээс:
Ялгагдах онцлог:
Зориулалт:

Иж бүрдлийн бүрэлдэхүүн хэсгийн мэдээлэл:

Хувийн дугаар	Тодорхойлолт	Хэмжээ

Хадгалалтын байдал:
Бүрэн бүтэн байдал: Бүрэн бүтэн
Чанар байдал: sain
Гэмтэл: Баруун доод хэсэгт 0,6х0,9 см цоорсон. Зарим хэсгээрээ наалт үрчийж хөндийрсөн.

Хамгаалалтад авсан шийдвэр:

Товч түүх:
Холбогдох газар, орон: Бүтэн очир завилгаа суудалтай, 2 мутартаа очир барьсан, зөөлөн амарлингуй дүртэй. Гоёл чимгийг сувд шүрээр хэлхэж чимэглэсэн, дээд хэсэгт нь нар, сар, цэцэг, навч, үүл, тэнгэр дүрсэлж, доор нь арга билгийг билэгдсэн догшин дүртэй бурхан дүрсэлсэн.
Хэрэглэж байсан хүн:
Цуглуулагчийн нэр: Улаанбаатар хотын музей
Бүтээлчийн түүх:

Бүртгэлийн түүх:
Хуучин хувийн дугаар: Y.52.462 УБТШБМ 99-С-502-1
Ерөнхий бүртгэлийн дэс дугаар: 330
Төрөлжсөн бүртгэлийн дэс дугаар: ОУ-3

Сэргээн засварлагдсан байдал:	СЗБ №

Хуулбар хийгдсэн байдал:

Үзэсгэлэнд оролцсон байдал:

Үзэсгэлэнгийн төрөл	Улс	Эхэлсэн огноо	Дууссан огноо	Үзэсгэлэнгийн нэр	Даатгалын үнэ

Шилжилт хөдөлгөөн:

Судлагдсан байдал:

Судлагдаагүй

Хавсралт материалын тэмдэглэл:

Бүртгэсэн:

/_____/ /_____/

/ Овог, нэр/ */Албан газар, албан тушаал/*

/20.... оны ..... сарын ..... -ны өдөр/

Байгууллага, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын нэгдсэн (доогуур зур) бүртгэл-мэдээллийн санд хадгалагдаж байгаа:

Д/д	Нэр төрөл	Тоо ширхэг	Хадгаламжийн дугаар
1	Гэрэл зураг		
2	Негатив хальс		
3	Дуу, дүрс бичлэгийн хуурцаг		
4	CD/DVD/BD		
5	Архив, ном, хэвлэлийн баримт		
6	Бусад		

Бүрдүүлэлт хийсэн:

/_____/ /_____/

/ Овог, нэр/ */Албан газар, албан тушаал/*

/20.... оны ..... сарын ..... -ны өдөр/

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ

УНБМС-ийн дугаар: ХД0057192

Өмчлөгч: Монгол улс	
Эзэмшигч: Улаанбаатар хотын музей	**РД:** 9097104

Музейн зэрэглэл:	Орон нутгийн

Дурсгалт зүйлийн оршин байгаа хаяг:

Дурсгалт зүйлийн нэр: Л.И.Брежнев	**Хувийн дугаар:** UBM82.2
Олон улс, орон нутаг, шинжлэх ухааны нэр: Оёмол урлаг	

Төрөл зүйл: 5. УРЛАГ, УРАН САЙХАН -> 5.4 Чимэглэлийн урлаг -> 5.4.2 Хатгамал

Холбогдох он цаг: XX зууны сүүлч үе

Соёлын өвийн зэрэглэл:	
Хосгүй үнэт	**Шийдвэр:**
Үнэт	**Шийдвэр:**

Эх бүтээл

Ховор, түгээмэл байдал:
Ашиглалтын байдал: Үзүүллэгт
Үнэлгээ: 3450000.00

Бүтээлчийн нэр:	Уран хатгамалч А.Цэрэнхүү
Дэг сургууль хийц:	
Материал, арга ажиллагаа: Даавуу, өнгийн утас, зэс, торгон утас	

Баримтжуулалтын гэрэл зураг:	**photo**	**photo**	**photo**

Хэмжээ	Өндөр	Өргөн (урт)	Зузаан	Голч	Жин
Ерөнхий	125.40	68.00, 0.00	0.00	0.00	0.00
Бусад хэмжээс: Жаазны өндөр 136 см, өргөн 78.5 см					

Иж бүрдэл: 1	Тоо ширхэг
	1
Гарал үүсэл:	

Тодорхойлолт:
Дүрслэн бичих: Л.И.Брежневийг улаан цоохор өнгийн хивс дээр, гоёмсог ширээний дэргэд зогсон, баруун гартаа нүдний шилээ барьж, цагаан цамц хүрэн бор зангиа, хар хүрэм өмсөж, энгэртээ ЗХУ-ын дөрвөн удаагийн баатрын цол тэмдэг, Социалист хөдөлмөрийн баатрын цол тэмдэг, Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол тэмдэг, хүзүүндээ БНМАУ-ын хүндэт иргэний цол тэмдэг зүүсэн байдлаар дүрслэн оёж хатган бүтээсэн. Тод ногоон өнгийн давхар хүрээ дотор бүдэг ногоон өнгийн үргэлжилсэн хээг дүрслэн оёж хатгасан.
Тэмдэг бичээс:
Ялгагдах онцлог:
Зориулалт:

Иж бүрдлийн бүрэлдэхүүн хэсгийн мэдээлэл:

Хувийн дугаар	Тодорхойлолт	Хэмжээ

Хадгалалтын байдал:
Бүрэн бүтэн байдал: Бүрэн бүтэн
Чанар байдал: sain
Гэмтэл: Зүүн доод буландаа хүрээ даавуу нь 2 газар сэмэрсэн.

Хамгаалалтад авсан шийдвэр:

Товч түүх:
Холбогдох газар, орон: Л.И.Брежневийг улаан цоохор өнгийн хивс дээр, гоёмсог ширээний дэргэд зогсон, баруун гартаа нүдний шилээ барьж, цагаан цамц хүрэн бор зангиа, хар хүрэм өмсөж, энгэртээ ЗХУ-ын дөрвөн удаагийн баатрын цол тэмдэг, Социалист хөдөлмөрийн баатрын цол тэмдэг, Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол тэмдэг, хүзүүндээ БНМАУ-ын хүндэт иргэний цол тэмдэг зүүсэн байдлаар дүрслэн оёж хатган бүтээсэн. Тод ногоон өнгийн давхар хүрээ дотор бүдэг ногоон өнгийн үргэлжилсэн хээг дүрслэн оёж хатгасан.
Хэрэглэж байсан хүн:
Цуглуулагчийн нэр: Улаанбаатар хотын музей
Бүтээлчийн түүх:

Бүртгэлийн түүх:
Хуучин хувийн дугаар: Y.131.482 УБТШБМ 99-С-486-1
Ерөнхий бүртгэлийн дэс дугаар: 329
Төрөлжсөн бүртгэлийн дэс дугаар: ОУ-2

Сэргээн засварлагдсан байдал:	СЗБ №

Хуулбар хийгдсэн байдал:

Үзэсгэлэнд оролцсон байдал:

Үзэсгэлэнгийн төрөл	Улс	Эхэлсэн огноо	Дууссан огноо	Үзэсгэлэнгийн нэр	Даатгалын үнэ

Судлагдсан байдал:

329. Л.И.Брежнев Тодорхойлолт: Уг хатгамал нь алтан боронзон хүрээтэй. Хатгамлыг тойруулан өнцөг булангийн хээ угалзыг ногоон хүрээтэйгээр чимэглэсэн. Хатгамлын голд ЗСБНХУ-ын Төв Хорооны Ерөнхий бичгийн дарга Леонид Ильич Брежневийг (1974 оны байдлаар нь) хар өнгийн хослолтой, нүдний шилээ баруун гартаа бариад, алтан шаргал өнгөтэй, хээ угалз болсон ширээ түшин, улаан өнгийн хээ угалзтай хивсэн дээр зогсож буйгаар дүрсэлжээ. Л.И.Брежневийн энгэрт түүний шагнуулж байсан медалиудыг дүрсэлсэн бөгөөд тэмдгүүдийн голд 1974 онд МАХН-ын 50 жилийн ойгоор БНМАУ-д айлчлахад нь олгосон "БНМАУ-ын Хүндэт иргэн" цол тэмдгийг дүрсэлжээ. Хатгамлын баруун доод буланд "А.ЦЭРЭНХҮҮ 1982" гэж улаан утсаар хатгажээ. Товч түүх: ЗСБНХУ-ын Төв Хорооны Ерөнхий бичгийн дарга Леонид Ильич Брежневийг БНМАУ-ын "Хөдөлмөрийн баатар" цолоор шагнагдсаныг тохиолдуулан уг бүтээлийг уран хатгамалч А.Цэрэнхүү 1982 онд торго, даавуу, зэс утсаар хатгаж бүтээжээ. Уг хатгамал хэрхэн, ямар байдлаар Улаанбаатар хотын музейн сан хөмрөгт орсон нь тодорхойгүй. Дурсгал хулгайд алдагдаж байгаагүй. Шагнал хүртэж байгаагүй. Дурсгалын түүх: ЗСБНХУ-ын Төв Хорооны Ерөнхий бичгийн дарга Леонид Ильич Брежнев нь 1906 оны 12-р сарын 19-нд Украины Камьянське хотод төржээ. Тэрээр 1964-1982 он хүртэл ЗХУКН-ын дарга, ЗХУ-ын төрийн тэргүүнээр ажиллаж байв. Л.И.Брежнев нь 1966 оны 1-р сарын 13-15-нд БНМАУ-ын анх удаагаа албан ёсоор айлчилсан бөгөөд тус айлчлалаар "БНМАУ-ЗСБНХУ-ын хооронд найрамдал, хамтын ажиллагааны болон харилцан туслалцах гэрээ"-г байгуулжээ. Тус гэрээний дагуу Зөвлөлтийн Алс Дорнод дахь армийн зарим анги нэгтгэлүүд БНМАУ-д шилжин ирж байрласан байна. 1974 оны 11-р сарын 25-нд БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойн баярт оролцохоор хоёр дахь удаагаа айлчилжээ. Уг айлчлалаар БНМАУ-ын 50 жилийн ойг тохиолдуулан ЗХУ-ын талаас БНМАУ-д хэд хэдэн барилга байгууламжийг бэлэг болгон барьж байгуулах тухай хэлэлцээрийг тус оны 11-р сарын 27-нд хийжээ. Хэлэлцээгээр БНМАУ-д 100 мянган м.кв сууцны талбай бүхий орон сууцны хорооллыг соёл, ахуй үйлчилгээний барилгын хамт, жилд 70 мянган м.кв сууцны талбай бүхий орон сууцны байшин үйлдвэрлэх 3 комбинат, Шинжлэх ухаан техникийн соёлын ордон, Гэрлэх ёслолын ордныг ЗХУ-ын хүч хөрөнгөөр бэлэг болгон барьж өгөхөөр болжээ. Энэхүү хэлэлцээрийн дагуу 1976-1986 оны хооронд III, IV хорооллыг барьж байгуулсан бөгөөд тус хороолол нь Улаанбаатар хотын хүн амыг орон сууцаар хангахад ихээхэн хувь нэмэр оруулсан юм. Мөн тус хорооллыг социализмын үед "Брежневийн бэлгийн цэнхрүүд" хэмээн нэрлэж байв. Л.И.Брежнев нь дотоод, гадаадын хамгийн олон медаль хүртсэн ЗХУ-ын удирдагч байв. 1991 оны баримтаар түүнд ЗХУ-ын 16 одон, 20 медаль, гадаад улсын 49 одон, 29 медаль байжээ. 1974 онд айлчлахад нь Ю.Цэдэнбалын санаачилгаар БНМАУ-ын баатар Хүндэт иргэн цол бий болгож, хүндэт иргэний Алтан таван хошуу тэмдгийн цорын ганц хувийг Л.И.Брежневт гардуулж байв. Харин 70 насны төрсөн өдрийн ойгоор нь буюу 1976 онд "БНМАУ-ын Баатар", 75 насны ойгоор нь 1981 онд "БНМАУ-ын хөдөлмөрийн баатар" цолоор шагнаж байжээ. Ном зүй: - Болдбаатар, Ч. Очбаяр, Г. Одсүрэн, О. Монгол Улс Нийслэл Улаанбаатар он дараллын бичиг, Улаанбаатар: 2023 - Болдбаатар, Ч. Дуламрагчаа, Ю. Нансалмаа, Э. Монгол Улс Нийслэл Улаанбаатар он дараллын бичиг, Улаанбаатар: 2014 - https://en.wikipedia.org/wiki/Awards_and_decorations_received_by_Leonid_Brezhnev Эрхлэн боловсруулсан эрдэм шинжилгээний ажилтан О.Одсүрэн

Хавсралт материалын тэмдэглэл:

Бүртгэсэн:

/_____/ /_____/

/ Овог, нэр/ */Албан газар, албан тушаал/*

/20.... оны ..... сарын ..... -ны өдөр/

Байгууллага, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын нэгдсэн (доогуур зур) бүртгэл-мэдээллийн санд хадгалагдаж байгаа:

Д/д	Нэр төрөл	Тоо ширхэг	Хадгаламжийн дугаар
1	Гэрэл зураг		
2	Негатив хальс		
3	Дуу, дүрс бичлэгийн хуурцаг		
4	CD/DVD/BD		
5	Архив, ном, хэвлэлийн баримт		
6	Бусад		

/ Овог, нэр/ */Албан газар, албан тушаал/*

/20.... оны ..... сарын ..... -ны өдөр/

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ

УНБМС-ийн дугаар: ХД0078332

Өмчлөгч: Монгол улс	
Эзэмшигч: Улаанбаатар хотын музей	**РД:** 9097104

Музейн зэрэглэл:	Орон нутгийн

Дурсгалт зүйлийн оршин байгаа хаяг:

Дурсгалт зүйлийн нэр: Түүхт Улаанбаатар	**Хувийн дугаар:** UBM74.2
Олон улс, орон нутаг, шинжлэх ухааны нэр: Сийлбэр	

Төрөл зүйл: 5. УРЛАГ, УРАН САЙХАН -> 5.3 Сийлбэр -> 5.3.3 Ясан сийлбэр

Холбогдох он цаг: XX зууны сүүлч үе

Соёлын өвийн зэрэглэл:	
Хосгүй үнэт	**Шийдвэр:**
Үнэт	**Шийдвэр:**

Эх бүтээл

Ховор, түгээмэл байдал:
Ашиглалтын байдал: Үзүүллэгт
Үнэлгээ: 8000000.00

Бүтээлчийн нэр:	С.Сэнгээ
Дэг сургууль хийц:	
Материал, арга ажиллагаа: Мод, яс,	

Баримтжуулалтын гэрэл зураг:	**photo**	**photo**	**photo**

Хэмжээ	Өндөр	Өргөн (урт)	Зузаан	Голч	Жин
Ерөнхий	0.00	12.60, 161.00	0.00	0.00	0.00

Бусад хэмжээс: Хэт урт 42 см, өргөн 24 см

Иж бүрдэл: 1	Тоо ширхэг
	1
Гарал үүсэл:	

Тодорхойлолт:
Дүрслэн бичих: Зааны соёон дээр сийлсэн дүрслэлийн утга санаа хоёр хэсгээс бүрдэх бөгөөд энэ хоёр хэсгийг ургаа модоор заагласан. Эхний хэсэгт сүм хийд, хашаа хороо, лам, ноёдыг дүрсэлж, ард хүн дөнгөнөөсөө салж буйг харуулсан. Хоёр дахь хэсэгт тухайн цаг үеийн Улаанбаатар хотын барилга, архитектур, хөшөө баримал, түүх, соёлын дурсгалыг дүрсэлсэн. Мөн дурсгалын дээд үзүүр хэсэгт Д.Сүхбаатарын морьтой хөшөө, соёмбо тэмдэг бүхий төрийн далбааг намирч байгааг дүрсэлсэн. Зааны соёон сийлбэрийг дагуулан маш нарийн сүлжмэл угалзаар чимэглэсэн. Сийлбэрийн төгсгөл хэсэгт "Улаанбаатар хотын 50 жилд" гэж уйгуржин монголоор бичсэн. Соёоны дунд хэсэгт цэцгээр суурь хийж өгсөн. Доод суурь нь саран хэт хэлбэртэй.
Тэмдэг бичээс:
Ялгагдах онцлог:
Зориулалт:

Иж бүрдлийн бүрэлдэхүүн хэсгийн мэдээлэл:

Хувийн дугаар	Тодорхойлолт	Хэмжээ

Хадгалалтын байдал:
Бүрэн бүтэн байдал: Бүрэн бүтэн
Чанар байдал: sain
Гэмтэл: Хагаралт цууралт үүссэн.

Хамгаалалтад авсан шийдвэр:

Товч түүх:
Холбогдох газар, орон: Зааны соёон дээр сийлсэн дүрслэлийн утга санаа хоёр хэсгээс бүрдэх бөгөөд энэ хоёр хэсгийг ургаа модоор заагласан. Эхний хэсэгт сүм хийд, хашаа хороо, лам, ноёдыг дүрсэлж, ард хүн дөнгөнөөсөө салж буйг харуулсан. Хоёр дахь хэсэгт тухайн цаг үеийн Улаанбаатар хотын барилга, архитектур, хөшөө баримал, түүх, соёлын дурсгалыг дүрсэлсэн. Мөн дурсгалын дээд үзүүр хэсэгт Д.Сүхбаатарын морьтой хөшөө, соёмбо тэмдэг бүхий төрийн далбааг намирч байгааг дүрсэлсэн. Зааны соёон сийлбэрийг дагуулан маш нарийн сүлжмэл угалзаар чимэглэсэн. Сийлбэрийн төгсгөл хэсэгт "Улаанбаатар хотын 50 жилд" гэж уйгуржин монголоор бичсэн. Соёоны дунд хэсэгт цэцгээр суурь хийж өгсөн. Доод суурь нь саран хэт хэлбэртэй.
Хэрэглэж байсан хүн:
Цуглуулагчийн нэр: Улаанбаатар хотын музей
Бүтээлчийн түүх: Урлагийн Гавьяат Зүтгэлтэн С.Сэнгээгийн намтар Самдангийн Сэнгээ нь 1924 онд Өвөрхангай аймгийн Хужирт суманд төрсөн. 1944 онд цэргийн албанд явж 1949 онд цэргээс халагдталаа гар урлал, сийлбэрээ хийсээр байлаа. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв хорооны 1954 оны 310 дугаар шийдвэрээр Гар үйлдвэрийн дээд зөвлөлийн харъяа Урчуудын артельд уран сийлбэрчнээр ажиллах болсон. 1945 -1975 он хүртэл улсад тасралтгүй 30 жил ажиллахдаа 3000 гаруй нэр төрлийн бүтээл хийснээс 210 орчим нь жинхэнэ нэр бүхий том хэмжээний уран бүтээл болж өөрийн болон гадаад орнуудын музей, үзэсгэлэн, галерейн үнэт үзмэр болон тавигджээ. Мөн үйлдвэрийн болон хүүхдийн тоглоом 100 гаруй нэр төрөл, сийлбэрийн эх загвар 1000 гаруйг хийж бүтээсэн байна. Энэ урлаж хийсэн бүтээлүүдээс нь 50 гаруй нь үзэсгэлэнд тавигдаж олон түмнээс өндөр үнэлэлт авч байсан. Мөн өөрийн болон гадаад орны уран бүтээлийн уралдаанд оролцож удаа дараа тэргүүн байруудад шалгарч байсан. Төв хороо, Засгийн газрын шийдвэрээр нам төрийн удирдлагууд гадаадад айлчлах болон гадаадын нам төрийн удирдлагууд айлчлан ирэх үед бэлэг дурсгал болгон захиалгаар хийлгэсэн уран бүтээлүүд нь дэлхийн 70 гаруй оронд эх орныхоо нэрийг гарган хадгалагдаж байдаг. С.Сэнгээгийн дотоод гадаадын сургууль курст суралцаж байгаагүй бөгөөд яс, модон сийлбэрийн мэргэжилтэй, 7-р зэргийн сийлбэрчин байсан юм. 1969 онд БНМАУ-ын Урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртсэн. С.Сэнгээгийн бүтээсэн нэр бүхий зарим бүтээлүүдээс нь дурьдвал: "Баян байгаль" модон сийлбэр (Өвөрхангай аймгийн музейд) "Бөхийж үзээгүй далбаа" зааны соёон сийлбэр (Монголын Уран Зургийн Галерейд) "Миний Улаанбаатар" зааны соёон сийлбэр (Улаанбаатар хотын музейд) "Есөн давхар шаарик" ясан сийлбэр (дэлхийд 2-рт ордог) "Халх гол" "Монгол-Зөвлөлтийн найрамдал" соёон сийлбэр "Октябрийн хувьсгалын 45 жил" "Октябрын хувьсгалын 50 жил" "Лениний 100 жил" (Ленинградад) "Найрамдал" 3 давхар ясан сийлбэр (Москвад) "Зөвлөлт төрийн бэхжилт" модон сийлбэр "Цэцгийн цомирлог" ясан сийлбэр (Куба улсад) "Шунхлай" "Хүрэн морь" цуврал модон сийлбэр "Ясан хөөрөг"

найрамдал” “Тээврийн хөгжил” соёон сийлбэр “Өндөр ургац” ясан сийлбэр “Алдарт барилгачин” ясан сийлбэр “Азарганы ноцолдоон” ясан сийлбэр “Аврора” ясан сийлбэр “Ленинизмийн тугийн дор” “Шүдэнзний хайрцагт багтдаг шатар” (Болгарт) “Шатар” (Чита хотод)

Бүртгэлийн түүх:
Хуучин хувийн дугаар: Y.17.427 УБТШБМ 99-С-481-1
Ерөнхий бүртгэлийн дэс дугаар: 316
Төрөлжсөн бүртгэлийн дэс дугаар: С-1

Сэргээн засварлагдсан байдал:	**СЗБ №**

Хуулбар хийгдсэн байдал:

Үзэсгэлэнд оролцсон байдал:

Үзэсгэлэнгийн төрөл	**Улс**	**Эхэлсэн огноо**	**Дууссан огноо**	**Үзэсгэлэнгийн нэр**	**Даатгалын үнэ**

Шилжилт хөдөлгөөн:

Судлагдсан байдал:

Тодорхойлолт: Зааны ясан сийлбэр. Эхлэл хэсэгт лам ноёд, сүм хийд, феодалуудыг дүрсэлсэн байх бөгөөд тэднийг нэгэн хүчирхэг булиа эр нухчин дарж, гав дөнгөө хугачин хаян босч ирж байгааг харуулсан. Дунд хэсэгтээ ургаа мод дүрсэлсэн. Үүнээс хойшхи дүрслэлд БНМАУ-ын үед боссон их бүтээн байгуулалтуудыг товойлгон харуулжээ. Үүнд тээвэр, хөнгөн, хүнд үйлдвэрүүд, бүтээн байгуулалт, хорооллууд, галт тэрэг, нисэх онгоцыг дүрсэлсэн байх бөгөөд соёоны үзүүр хэсэгт Сүхбаатарын хөшөөг, цаана нь намирах туган дээр соёмбо тэмдгийг дүрслэн харуулжээ. Зааны соёон сийлбэрийг дагуулан маш нарийн сүлжмэл угалзаар чимэглэсэн. Сийлбэрийн төгсгөл хэсэгт "Улаанбаатар хотын 50 жилд" гэж уйгуржин монголоор бичсэн. Соёоны дунд хэсэгт цэцгээр суурь хийж өгсөн. Доод суурь нь саран хэт хэлбэртэй. Улаан өнгийн даавуун дэвсгэртэй, нэг өнцөг нь ромбо хэлбэрийн, нэг тал нь тэгш өнцөгт хэлбэрийн хайрцагтай. Товч түүх: Үйлдвэр хоршооллын төв зөвлөлийн удирдлагын зүгээс урчууд маань дорвитой томоохон бүтээл хийх шаардлагатай байна гэж НТХ-нд хүсэлт тавьсны дагуу 1963 онд 2 улсын хэлэлцээрийн дагуу БНЭУ-д С.Сэнгээ өөрийн биеэр явж сийлбэр хийх зааны соёонуудаа авчирсан түүхтэй. Монголын Урчуудын эвлэлийн уран бүтээлчид БНМАУ-ыг тунхагласны болон Улаанбаатар хотын 50 жилийн ойд зориулан 413 бүтээл бүхий үзэсгэлэн зохион байгуулсан ба Сийлбэрч С.Сэнгээ энэхүү ойд зориулан "Түүхт Улаанбаатар" сийлбэрээ 1974 онд зааны соёон дээр урласан. Сийлбэрийн тухай ерөнхий ойлголт Сийлбэрийг ихэвчлэн мод, чулуу, ясаар хийдэг. Хүн, малын дүрс, ургамал, төрөл бүрийн хээ угалзыг сийлдэг. Тусгай багажаар мод, чулуу, яс зэргийг хасах аргаар сийлж чимэглэж хийсэн эдлэлийг сийлбэр гэнэ. Сийлбэр нь дараах 6 төрөлд хуваагдана. Үүнд: 1. Бүтэн сийлбэр – тал бүрээс нь харж болох сийлбэр 2. Хагас товгор сийлбэр - дэвсгэрээс дүрсийг товойлгон сийлнэ. 3. Хавтгай сийлбэр – дүрсийг дэвсгэртэй нэг түвшинд сийлнэ. 4. Цоолбор сийлбэр – дүрсийг хүрээ зураасаар цоолж сийлнэ. 5. Хүрээлбэр сийлбэр – дүрсийг мөн адил хүрээ зураасаар сийлнэ. 6. Хотгор сийлбэр – дэвсгэрийн гүнд дүрсийг ухаж сийлнэ. Сийлбэр хийхэд хуш, хус, хүрэн ба цагаан зандан, яшил, арцны иш, буйлс, сухай, агар, хатир, далийн хальс гэх мэт модон материалууд хэрэгтэй боловч анхлан сийлбэр хийж сурахад хуш, хус ба зөөлөн баргилт чулуу сонгоход тохиромжтой. Хийсэн материалаас шалтгаалан ясан, чулуун, модон, метал сийлбэр гэж ангилна. Мөн монголд байдаггүй гадаад материалд зааны яс, хүрэн зандан, хар ум, сэндэн, агар гоньд, янчин, чавганы мод, суман, агар арцны мод, Батцагаан, бук зэргийн модууд орно. Зааны соёо нь хэврэг, амархан үйрдэг, олдоц багатай, үнэтэй байдаг учраас тухайн урлаж буй сийлбэрчнээс маш их нарийн ур чадвар шаарддаг байна. Яс эвэр сийлэх багажууд: Цүүц, өрөвтөл багаж, гурвалжин иртэй цүүц, хавтгай цүүц, махир үзүүртэй цүүц, өрөвтөл иртэй багажнууд Зааны соёоны тухай Зааны соёо нь бүдүүнээрээ дээд тал нь 15-20 см байдаг ба жин нь 70 кг, уртаараа 1м 70 см ч байдаг юм. Зааны соёо нь доод талдаа, голдоо, тал дундаа хүртэл нүхтэй ба дээд талдаа цул байна. БНХАУ дахь зааны ясаар сийлбэр хийдэг хүмүүс зааны соёо, ясаар үнэхээр гайхалтай зүйлс сийлдэг. Зааны соёон томоохон сийлбэр нь Синсиннатигийн урлагийн музейд хүртэл байдаг байна. Музейд тавигдах хэмжээнд, дуудлага худалдаагаар наймаалах хэмжээнд зааны ясан эдлэл, соёогоор хийсэн эд зүйлс үнэд ордог. Дэлхий нийтээрээ 1989 оноос эхлэн зааны соёо болон ясаар бүтээсэн бүдээгдэхүүний худалдааг хориглосон. Олон улсын байгаль хамгаалах, ан амьтны тоо толгойн хяналтын байгууллага 2008 онд зааны тоо толгойг хамгийн сүүлд гаргасан. Үүний өмнө 1979 онд 1,3 сая заан Африк тивд байгаа ба дэлхий дээр нийт гурван сая орчим заан тоологдсон гэж тэмдэглэжээ. Харин 1989 онд буюу 10 жилийн дараа 600 мянга болон буурч дэлхий нийтийг цочирдуулсан. Төв Африкт 277 мянга, зүүн Африкт 110 мянга, өмнөд Африкт 204 мөн баруун Африкт 19 мянга гаруй заан үлдсэн харамсалтай тоо судалгаа гарсан билээ. Ингээд манай дэлхийн түүхэнд 1979-1989 оны хооронд нийт зааны тоо толгой 74 хувиар буурсан үзүүлэлт гарснаас хойш Камерун, Сомали, Замбиа, Мозамбик, Ангол, Ботсвани, Зимбабе зэрэг орон зааныг өндөр хамгаалалтад авсан билээ. БНХАУ зааны соёо болон зааны ясан сийлбэр бүхий бүтээгдэхүүний худалдааг зогсоохоо мэдэгдээд байна. Мөн дэлхий нийтээр 1989 оноос хойш зааны соёо болон ясаар бүтээл хийх, бүтээсэн бүтээгдэхүүнийг худалдаалахыг хориглосон учраас уг үзмэр нь цаг хугацаа улирах тусам үнэ цэнээ улам нэмэх бизээ. Тиймээс бүтээлийн он цагийн хувьд, мөн зааны соёон нь олдоцын хувьд ч маш ховордож байгаа тул энэхүү бүтээлийг Улаанбаатар хотын музейн нэрийн өмнөөс "Хосгүй үнэт" бүтээлд нэр дэвшүүлж болох юм гэж үзэж байна. Уг бүтээлийн түүхээс дурдвал: 1. Уран сайхны фондын хорооны тэргүүлэгчдийн 1974 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 8/4 дугаар хурлын тогтоолын хавсралт №1-д 1-р байранд С.Сэнгээгийн "Түүхт Улаанбаатар" сийлбэр нь бусад 16 бүтээлийн хамт шалгарч 5000 төгрөгөөр үнэлэгдсэн байна. 2. МУЭХ-ийн хорооны 1974 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Бараа материал бүтээгдэхүүн олгосон зарлагын падаан №20-д бичсэнээр Түүхт Улаанбаатар – ясан сийлбэрийг 5000 төгрөгөөр Улаанбаатар хотын музейд худалдан авсан байна. 3. 1976 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн Улаанбаатар хотын түүх шинэчлэн байгуулалтын музейн үзмэрт байгаа зүйлсийн жагсаалтад дурдсанаар музейн 8 дугаар өрөөнд уг сийлбэрийг үзүүлэнд тавьсан байна. 4. Р.Бат-Очир "Урчуудын тухай тэмдэглэл" (1984 он) номонд: Зааны соёоны хэлбэрийг дагуулан маш нарийн сүлжмэл угалзаар чимэглэн, их удирдагчийн олон түмнийг уриалан дуудсан байдлыг харуулсан зохиомж сонгон авсан байна. Зааны ясаар сийлбэр хийх явдал бүтээлчээс их чадвар, ур шаарддаг. Сэнгээгийн бүтээсэн олон сайхан сийлбэр манай орчин үеийн чимэх, чимэглэх урлагт хүндтэй байр эзлэн өвөрмөц дуу хоолойгоо өргөсөн болно хэмээн бичжээ. 5. Улаанбаатар хотын түүх шинэчлэн байгуулалтын музейн эрхлэгчийн 1988 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 11 дүгээр тушаалд Найрамдлын районы өндөр настан Нанзадын хийж (бусад 14 ш) өгсөн Түүхт Улаанбаатар – сийлбэрийн диапозитивыг 20 төгрөгөөр үнэлэн худалдан авсан байна. 6. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын газраас 1999 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 141 дүгээр албан хүсэлтээр Нийслэлийн 360 жилийн ойд зориулан 1999 оны 10 дугаар сарын 26-нд музейнүүдийн шилмэл

Монголын Үндэсний музейн захирлын 2026
оны.08. дугаар сарын ..12..-ний өдрийн.02/143
дугаартай албан бичгийн хавсралт

Монголын Үндэсний музейгээс Үнэт үзмэрийн жагсаалтад бүртгүүлэх үзмэрийн жагсаалт

Улаанбаатар хот

2026 оны 08 дугаар сарын ...

№	Үзмэрийн нэр	Хувийн дугаар	Тоо /ш	Хэмжээ	Журмын 2.1.6 (УБМС-ийн дугаар)	Журмын 2.1.5 (Судлагдсан, сурталчлагдсан байдал)	Саналын үндэслэл	Зураг
1	Руни бичигтэй нумын ясан наалт	Ү.2007-2-39	1 хос	Урт: 16.3 см Өргөн: 2.2 см Зузаан: 0.2-0.4 см	ХД0067857	А.Очир, Ц.Баттулга “Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа (2022)”, Боть 2-ын 38-р талд хэвлэгдсэн.	Архангай аймгийн Хотонт сумын нутаг, Хулхын амны Дөрвөлжин хэмээх газар Уйгурын үед холбогдох цөөнгүй бунхант булш буйг эрдэмтэд илрүүлж, улмаар 2006, 2007 онуудад Монгол Үндэсний музей, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө засах орны Соёлын өв, Археологийн хүрээлэнтэй хамтран малтаж судалсан. Малтлага судалгаагаар (14-р бунхнаас) нумын ясан наалт хоёр ширхэг илэрсэний нэг наалт дээр, таван дүрс үсэг бүхий бичгийг хурц үзүүртэй зэмсгээр зурж бичсэн байжээ. Уг бичээсийг анхлан доктор (Sc.D) А.Очир, Ц. Баттулга нар 2007 онд судлан хэвлүүлжээ. Археологийн судалгааны ажлын тайланд “Ясан наалтууд нь цагаан шаргал өнгөтэй, хоёр үзүүр лүгээ хурц өнцөг бүхий шувтан хэлбэртэй. Нумын үүсгүүрт наах хэсгээрээ хавтгай, нөгөө тал нь бага зэрэг төвгөрдүү. Голоороо бага зэрэг зузаан, гадна ирмэг тийшээгээ нимгэн. Наалтын их биеийг хөвөөлүүлж, хооронд нь огтлолцуулан гүн бус зурчмал хээ гаргажээ. (Очир.А, Баттулга.Ц) гэж тэмдэглэсэн байна.	

							Бичээсийн үсгийн тиг хэлбэр тогтсон, үсэг тэмдэгтийг жигд, тун чадварлаг бичсэн нь бичигч руни бичгийг сайн эзэмшсэн нэгэн болохыг илтгэнэ. Үгийн галиг: Tunuz (tonuz) Орчуулга: Тунуз (Тонуз) хүний нэр. Нум элэгдэж хуучраагүй, үсэг тэмдэгт бүдгэртэл хэрэглээгүй, шинээрээ мэт буй нь анхаарал татна. Тунуз (Тонуз) нь нумыг эзэмшигчийн нэр үү эсвээс нумын ясан элгэн наалтыг үйлдэж хийсэн хүний нэр үү гэдгийг тодорхойлж тогтоох боломжгүй. Нүүдэлчдийн зэр зэвсэг, багаж хэрэгсэл дэх хувь эзэмшигч, эсхүл тэмдэглэгээ бүхий бичиг үсэгтэй дурсгал археологийн малтлага судалгаагаар ховор олддог тул руни бичиг үсэг бүхий цөөн дурсгалын нэгд зүй ёсоор тооцогддог тул үнэ цэнтэй үзмэр болно.	
2	Өндөр суурьт аяга	МҮМ20 13.6.6	1	Өн: 17.5 см, Амсрын голч: 7.2 см, Суурийн голч: 2.2-2.3 см.	ХД0122285	“Нүүдэлчдийн аяга”(2024) каталогийн “Монголын Эзэнт гүрний өндөр суурьт аяга” хэсэгт 74-75-р талд, “Нүүдэлчдийн өв судлал”(2024) Tomus XXV, Fasc-5-ын 75-83-р талд “Монголын Эзэнт гүрний өндөр суурьт аяга” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл тус тус хэвлэгдсэн.	2013 оны 06 дугаар сард Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутаг Хөндлөн Цанхир уулын зүүн урд аманд орших хөмөгт оршуулгаас Монголын Үндэсний музейн судлаач археологичид монгол нутгаас ***анх удаа*** өндөр суурьт модон аягыг олсон байна. Энэ аяга нь Монгол нутгаас биет байдлаар олдсон дундад зууны үеийн язгууртан ноёдын аяганы онцлог хэв шинжийг агуулсан түүх-угсаатны үнэ цэн бүхий биет дурсгал юм. Анх олдоҳдоо зан үйлийн зорилгоор цуулсан бололтой шинэхэн ул мөртэй ба аяганы хоёрны нэг нь хадгалагдан үлджээ. Аяга амсар луугаа үл ялиг нимгэрсэн тэгш босоо ханатай. Аяганы амсрыг нарийн зураасаар хөвөөлсөн бөгөөд их биеийн дундуур гурван эгнээ, мөн ёроолд гурви татсан байна. Суурийн дунд хэсэгт товгор (бөгж) гаргасан нь барихад эвтэй болгожээ. Мөн аяганы ёроолд эргэх хүрдний ором, хурц багажаар сийлсэн шинж тэмдэг, өмнө нь хагарч байсныг нарийн сураар холбож үдэж байсан нүхний оромтой.	 

							Дундад зууны үеийн Перс номын чимэг зураг болон хөшөө чулуунд монгол хаан болон язгууртан ноёдыг баруун гартаа өндөр суурьт аяга барьсан байдалтай дүрслэж ирсэн нь тэдний өндөр дээд язгуур угсааг илэрхийлж байсны нэгэн хэв шинж бөгөөд оршуулганд ч мөн адил дагалдуулсан нь нас барагчийн удам угсааг илэрхийлж буй бололтой. Тус дурсгал нь дундад зууны үеийн монгол язгууртан, ноёд болон ахуй байдал, оршуулгын зан үйл, эд хэрэглэлийн тухайд чухал үнэ цэн бүхий дурсгал юм.	
3	Нийслэл Хүрээний Голын Чойжон сахиусын сүмийн хувраг тушаалтны захирах тамга	Y.71-57-18	1	Өндөр: 7.5 см, 10.5 х 10.5 см Зузаан: 2.4 см Жин: 2940 гр 900 сорьцтой мөнгөн тамга.	ХД0116260	Монгол төрийн чойжин Лувсанхайдав, эх дагина Сүрэнхорлоо. Хамтын бүтээл (2016, 2019, 2023)-ийн 69, 71-р талд, Чойжин ламын сүм музей (2024) бүтээлийн 19-р талд, “Нүүдэлчдийн өв судлал” (2015) Tomus XXV, Fasc-5-д “Нийслэл хүрээний голын чойжон сахиусын сүмийн хувраг тушаалтныг захирах тамга” эрдэм шинжилгээний өгүүлэл, Монгол	Эрдэнэ билигт тунгалаг бишрэлт хутагт Лувсанхайдав нь монгол төрийн сахиусны гүдэнба буюу монгол төрийг даасан сахиусыг оршоон буулгагч хутагт буюу олонд алдаршснаар чойжин лам байсан бөгөөд хутагтын, гүдэнба ламын, Найчин сахиусны, харьяат сүмийн лам хуврагийг захирах 4 тамгатай байв. Тэдгээрийн нэг нь Монголын Үндэсний музейд хадгалагдаж буй “Нийслэл Хүрээний голын чойжон сахиусны сүмийн хувраг тушаалтныг захирах тамга” юм. Уг тамгыг VIII Богд хааны зарлигаар 1915 онд шагнан олгожээ. Тамганы голд соёмбо, соёмбоны хоёр талаар “Нийслэл Хүрээний голын чойжон сахиусны сүмийн хувраг тушаалтныг захирах тамга”, тамганы бариулын зүүн дээд мөрөнд “Олноо өргөгдсөний 5 дугаар он (1915) хөхөгчин туулай жилд”, баруун дээд талд “ёслолын хэрэг хавсарсан дотоод яам үйлдэв” гэсэн монгол бичгээр тус тус бичсэн. Тус тамга нь: 1-рт XX зууны эхэн үеийн Монголын төр-шашны харилцааны онцлогийг илэрхийлэх; 2-рт: XX зууны эхэн үеийн монголын сүм хийдийн лам хуврагуудыг захирах тамганы хийц, онцлогийг харуулах;	  

						Улс.1911-1919. (2015) каталогийн “Нийслэл Хүрээний голын чойжон сахиусны сүмийн хувраг тушаалтныг захирах тамга” өгүүллийн 158-161-р талд тус тус хэвлэгдсэн.	3-рт Нийслэл Хүрээний голын чойжин сахиусын сүм буюу монголын төрийн сахиусын сүмд холбогдож байгаагаараа түүхэн үнэ цэн бүхий биет дурсгал болно.	
4	Луу бариултай хос домбо	Y.66x-56-2	1 хос	Өндөр: 38 см, Амсрын голч: 10 см, Ёроолын голч: 15 см, Жин: 1555 гр	ХД0066120	Монгол улс.1911-1919. (2015) каталогийн 42-46-р талд “Богдын цайны домбо, хатны ташуурын тухайд” гэсэн хэсэгт хэвлэгдсэн.	1966 оны 06 дугаар сарын 03-ны Улсын Төв музейн үзмэрт үнэ тогтоох ба үзмэр худалдан авах комиссын хурлын №56 тоот тогтоолоор Сүхбаатар районы ОСГ 4-р хорооны харьяат Засгийн газрын 64 айлын сууцны 4-р орц 41 тоотын иргэн Ганжуурын Мандахаас “Урьд эцэг эх нь Богдын хураагдал хөрөнгөн дээрээс худалдан авсан 9 луу хээтэй луу бариултай пойлоосон домбо 2 нь Богд Живзундамбыг хаан ширээнд суухад нь цай барьсан юм гэнэ” гэснийг эш үндэс болгон 500 төгрөгөөр худалдан авсан байна. Уг хос домбо нь цэцгэн болон луун хээгээр битүү чимэглэсэн 4 бүслүүр, амаа ангайн хүрхэрч буй лууны дүрст бариул, цэцгэн суурьтай буурцаг хэлбэрт дог бүхий тагтай. Тус хос домбо нь: 1-рт түүхэн үйл явдал 1911 оны Монгол Улсын “Хаан ширээнд залрах ёслол үйл ажиллагаа”-д холбогдол бүхий; 2-р Түүхэн үйл явдал болох Богд Живзундамбын хөрөнгийг ард иргэдэд нээлттэй худалдсан тухайн үеийн төр засгийн үйл явдлыг дам гэрчлэх; 3-рт XIX-XX зууны үеийн эдийн соёлын хөгжил, хэв маяг, ур хийцийг илтгэх зэрэг	  

							түүх болон соёл урлагийн үнэ цэн бүхий дурсгал болно	
5	БНМАУ-ын Ерөнхий сайд Х.Чойбалсангийн “Маршалын од” одон	Y.62-8-290	1	Голч: 7.5 см	ХД0099497	Монголын Үндэсний музейн шилдэг үзмэрүүд (2018) каталогийн 364-р талд хэвлэгдсэн.	Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Маршалын од хэмээн онцгойлох одонг БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны тогтоолоор баталж, Ерөнхий сайд Х.Чойбалсанд олгожээ. Маршалын одны төв хэсэгт улаан таван хошуу, БНМАУ-ын сүлд (1940 он), түүнээс цацарсан алтан цацрагтай ажээ. Тус одонгийн нарны алтан цацрагийг алтаар, таван хошууг очир алмас болон улаан бадмааараг эрдэнийн чулуугаар үйлджээ. Таван хошууны төв дунд өнгө ялгабүрийн паалангаар хийсэн цагаан алтан хүрээ бүхий төрийн сүлд байна. Одонгийн загварыг БНМАУ-ын Урлагийн гавьяат зүтгэлтэн Д.Чойдог гаргажээ. БНМАУ-ын захиалгаар хийгдсэн 1940 оны цор ганц бөгөөд төрийн зүтгэлтний хэрэглэж байсан одон болно.	

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙ